



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2026 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 299

Улаанбаатар хот

Хүүхдийн зуслангийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Хүүхдийн зуслангийн үйл ажиллагааны чанар, хүртээмжийг сайжруулах, хүүхэд эрүүл, аюулгүй орчинд амрах, хөгжих боломжийг бүрдүүлэх чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар санал боловсруулж, 2026 оны 4 дүгээр улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Боловсролын сайд Л.Энх-Амгалан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир нарт даалгасугай.

2.Хүүхдийн хөгжил, төлөвшлийг дэмжихэд чиглэсэн сургалт, үйл ажиллагааны жишиг хөтөлбөрийг ерөнхий боловсролын сургуулийн хичээлээс гадуурх үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан баталж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Боловсролын сайд Л.Энх-Амгаланд даалгасугай.


3.Багш бэлтгэдэг их сургууль, коллежийн оюутан, суралцагчдын дадлагын ажлыг хүүхдийн зуслан түшиглэн зохион байгуулах, багц цагаар тооцох, сургалтын байгууллагын эмч, тогооч зэрэг мэргэжлийн боловсон хүчнийг зуны улиралд хүүхдийн зусланд ажиллах боломж, нөхцөлийг бүрдүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх асуудлыг судалж танилцуулахыг Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр, Боловсролын сайд Л.Энх-Амгалан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир нарт даалгасугай.

4.Хүүхдийн зуслангийн эко систем, ногоон орчныг хамгаалах, цэвэр, бохир усны байгууламж болон хог хаягдлын менежментийг холбогдох стандартад нийцүүлэх чиглэлээр дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Ц.Сандаг-Очирт, зуслангийн үйл ажиллагааг эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангах асуудлыг судалж, шаардлагатай арга хэмжээ авахыг Эрчим хүчний сайд Б.Найдалаад, зуслангийн барилга байгууламжийн нэг маягийн зураг ашиглах чиглэлээр дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгаланд тус тус үүрэг болгосугай.

5.Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаанд эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг сайжруулж, эмчлэх эрхийн зөвшөөрөлтэй эмч, эмнэлгийн ажилтан

ажиллуулах чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийн сайд Э.Батшугарт, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, дарамт, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх, холбогдох норм, стандартын шаардлагыг мөрдүүлэх, үйл ажиллагааны явцад хяналт тавьж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Онцгой байдлын ерөнхий газар (Г.Ариунбуян)-т тус тус даалгасугай.

6.Энэ тогтоолын хэрэгжилтийг хангаж, үр дүнг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакирт үүрэг болгосугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

БОЛОВСРОЛЫН САЙД

ШТА1206 9023100394 5498449

Н.УЧРАЛ

Л.ЭНХ-АМГАЛАН